



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Улаанбаатар хот

2020 он

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ.....	4
2. ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ.....	6
3. МОНГОЛ УЛСЫН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	7
4. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ ТООЦОХ АРГАЧЛАЛ	12
4.1 МАКРО ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ.....	14
4.2 УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨЛЛИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ	17
5. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР.....	24

Хүснэгт, зургийн жагсаалт

Хүснэгт 1. Аргачлалд ашиглах салбаруудын код, нэр	14
Хүснэгт 2. Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ	22
Хүснэгт 3. Эдийн засгийн нөлөөллийн тооцооллын хүснэгт	23
Зураг 1. Биеийн тамир, спортын салбарт мөрдөгдөж буй хууль эрхзүйн орчин.	5
Зураг 2. Биеийн тамир, спортын салбарын эдийн засгийн нөлөөллийн бүдүүвч ...	12
Зураг 3. Эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн загвар.....	13
Зураг 4. Арга хэмжээний эдийн засгийн нөлөөллийн бүдүүвч	17

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
БТКУС	Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ЭЗҮАСА	Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Олон улсын спортын тавцанд Монгол Улсын тамирчдын үзүүлж байгаа амжилт нь тусгаар тогтнолоо бататгах, улс орны хөгжлийн түвшинг илэрхийлэх, эх оронч үзлийг сурталчлахад онцгой ач холбогдолтой билээ. Түүнчлэн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөн, спортын үйл ажиллагаа нь бүх нийтэд хүртээмжтэй, тогтвортой байснаар хувь хүний хөгжлийг дэмжих, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх хамгийн үр дүнтэй, аюулгүй, нийгэм-эдийн засгийн үр ашигтай аргын нэг юм.

Спортын үнэ цэнэ нь орон нутгийн засаг захиргаа, иргэдийн амьдралын эрч хүч, итгэл үнэмшил эрүүл амьдралын хэв маяг гэх мэт бидэнд маш өргөн цар хүрээтэй нөлөөлж байдаг. Нийгэм, хувь хүмүүст, тэр дундаа эдийн засгийн өсөлтөд ашиг тусыг бий болгоход спортын үүрэг чухал нөлөөлдөг. Мөн эдийн засгийн хөгжил цэцэглэлтийг нэмэгдүүлэх, ажлын байраар хангах, спортоор хичээллэгчдийн хүсэл эрмэлзэл, ур чадварын түвшин дээшлүүлэхэд хувь нэмрээ оруулдаг.

Манай улсын хувьд нийт зохион байгуулагдсан спортын арга хэмжээний 60.4% нь сургууль, ААНБ-ын арга хэмжээ, 26.8% нь сум, дүүрэг, баг хороодын зохион байгуулсан үйл ажиллагаа бол 7.1% нь аймаг, нийслэлийн чанартай байна. Эндээс үзэхэд спортын чиглэлийн тэмцээн уралдаан хөдөө орон нутагт төдийлөн зохион байгуулагддаггүй байна.

2018 онд бүх нийтийг хамарсан аялал, өдөрлөг, чийрэгжилтийн арга хэмжээг 561 удаа зохион байгуулж, түүнд давхардсан тоогоор 760.8 мянган хүн оролцжээ. Тухайлбал, нийслэлийн иргэдийн спортын наадмыг 7 төрөл /спорт явган аялал, ширээний шагай, хийн дасгал, аэробик, олс таталт, гар бөмбөг, сагсан бөмбөг/-өөр, хэсэг, хороо, бүс, дүүрэг, нийслэл гэсэн 5 үе шаттайгаар зохион байгуулж, нийт 90 мянган иргэд оролцсон байна. Мөн түүнчлэн “Улаанбаатар марафон-2018” олон улсын гүйлтийг 7 зайн төрөлд зохион байгуулж, 32.0 мянга гаруй хүн оролцсон байна.

Цаашид биеийн тамир спортыг салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх, түүний нийгэм эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг тооцож олон нийтэд сурталчилж байх нь зүйтэй.

Дэлхий дахинаа эрүүл чийрэг бие бялдрыг эрхэмлэх болсон өнөө үед уг салбарын эдийн засагт эзлэх байр суурийг тодорхойлох нь хөгжлийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох чухал ач холбогдолтой юм.


- Биеийн тамир, спортын салбарын байгууллагууд хамтын ажиллагааг бэхжүүлэх, спортын ажил, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, мэдээллийг бодлогод илүү дэлгэрэнгүй байдлаар ашиглах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

- Биеийн тамир спортын салбарын нийгэм, эдийн засагт үзүүлж буй нөлөөллийг судлах, эдийн засагт эзэлж буй байр суурийн бодитой тооцоолох шаардлагатай

Дээрх шаардлагын үүднээс салбарын эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцох үндэсний аргачлалыг боловсруулж байна

Биеийн тамир спортын салбарын эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг тооцох аргачлал боловсруулах хүрээнд манай улсын хэмжээнд мөрдөгдөж буй хууль эрхзүйн орчин, ҮТС, макро эдийн засгийн үзүүлэлт тооцох аргачлалд тулгуурлан боловсруулах чиглэл баримталж байна.

Зураг 1. Биеийн тамир, спортын салбарт мөрдөгдөж буй хууль эрхзүйн орчин.



Биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар төрөөс баримтлах бодлого

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого / 2016 -2025 он/

Дээрх хууль эрх зүйн орчинд нийцүүлэн энэхүү аргачлалыг боловсрууллаа.

2. ОЙЛГОЛТ ТОДОРХОЙЛОЛТ, АНГИЛАЛ

Дотоодын нийт бүтээгдэхүүн (нэмэгдэл өртөг): Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийг тооцно. Нийт үйлдвэрлэлийг үндсэн үнээр, завсрын хэрэглээг худалдан авагчийн үнээр үнэлнэ. Мөн тухайн салбарын нэмэгдэл өртгийн дүн дээр бүтээгдэхүүний татварыг нэмж, татаасыг хасаж, ДНБ-ий хэмжээ зах зээлийн үнээр тодорхойлогдоно

Барааг тодорхойлох уялдуулсан систем: Дэлхийн гаалийн байгууллагаас 1983 онд "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн тухай олон улсын конвенцыг баталсан. Уг олон улсын ангилал нь дэлхийд өрнөж буй үйл явц нь улс орнуудыг гадаад худалдаанд зохицуулалт хийх, барааны урсгалыг хяналтдаа авах, ялангуяа олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдаж байгаа стратегийн ач холбогдол бүхий барааны хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах ач холбогдолтой юм.

Статистикийн бизнес регистр: Аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, регистрийн дугаар, хөрөнгө, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ (аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлого, үндсэн хөрөнгийн хэмжээ), ажиллагчдын тоо, цалин, үйл ажиллагааны чиглэл зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг багтаасан мэдээллийн санг ойлгоно.

Хариуцлагын хэлбэрийн ангилал: Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын баталсан ангиллыг мөрдөнө.

Өмчийн хэлбэрийн ангилал: Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн төрийн захиргааны байгууллагаас баталсан ангиллыг мөрдөнө.

Хөдөлмөрийн насны хүн ам: 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна.

АШИГЛАГДАХ АНГИЛАЛ

Биеийн тамир, спортын салбарын эдийн засгийн үзүүлэлт тооцоход дараах ангиллыг ашиглана. Үүнд:

1. Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны ангилал – 4.0
2. Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем

3. МОНГОЛ УЛСЫН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ


Дэлхийн улс орнуудын хөгжлийн түүхээс харахад эрт үеэс уламжлагдан ирсэн тоглоом, наадам, үндэсний спорттой байдаг. Түүх судлаачид Монголын соёлын өвийн нэг болох эрийн гурван наадам нь Монгол Улсын спортын түүхэн эхлэл гэж үздэг. Орчин цагийн спортыг 1921 оноос эхлэн хөгжүүлж ирсэн бөгөөд эдүгээ зарим спортын төрлөөр олимп, дэлхийн түвшинд өрсөлдөх хэмжээнд хөгжөөд байна.

Биеийн тамир, спортын салбарын 2017 оны батлагдсан төсөв нь улсын төсвийн 0.49 хувийг эзэлж, шат шатны төрийн байгууллагуудад 496 хүн ажиллаж биеийн тамир, спортын ажил үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Сүүлийн жилүүдэд спортын амжилт өндөр байгаатай холбоотойгоор иргэдийн спортоор хичээллэх идэвх сонирхол нэмэгдэж, үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, спортын клубийн тоо нэмэгдэж байна. Хувийн хэвшил болон төрийн бус байгууллагууд иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлж байгаа ч орон нутагт энэ төрлийн ажил үйлчилгээ эрхлэх нь бага байна.

Биеийн тамир, спортын салбарын захиргааны статистикийг сайжруулах зорилгоор 2007 оноос биеийн тамир, спортын захиргааны статистикийн маягтыг 5 чиглэлээр мэдээллийн агуулгыг өргөжүүлсэн байна. Биеийн тамир, спортын улсын тооллогыг 2017 онд зохион байгуулсан байна. Тооллогод Биеийн тамир, спортын салбарт үйл ажиллагаа явуулдаг өмчийн бүх хэлбэрийн байгууллага, иргэдийн эзэмшлийн спортын барилга, байгууламж болон биеийн тамир, спортын цол зэрэгтэй тамирчин, дасгалжуулагч, шүүгчдийг хамруулжээ.

Биеийн тамир, спортын 2017 оны тооллого судалгааны хэсгээс доор дурдав.


Зураг 1. Спорт цогцолбор, өмчийн хэлбэрээр



Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын үзлэг тооллого 2017

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй спорт цогцолборуудын 40 (70.2%) нь төрийн өмчийн, 6 (10.5%) нь орон нутгийн өмчийн, 6 (10.5%) нь Монгол Улсын иргэний, 3 (5.3%) нь хувийн ААНБ-ын өмчийнх байна.


Зураг 2. Спорт цогцолбор, өмчийн хэлбэрээр



Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын үзлэг тооллого 2017

Хувийн аж ахуйн нэгж, байгууллагын нийт 24 заалны 18 (75.0%) нь хувийн өмчийн, 2 (8.3%) нь гадаад улсын хувийн аж ахуйн, нэгж байгууллагынх бол 4 (16.7%) өмчийн бусад хэлбэрийн байгууллагын заал байна.

Зураг 3. Зохион байгуулагдсан спортын арга хэмжээний тоо




Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын үзлэг тооллого 2017

Улсын хэмжээнд нийт зохион байгуулагдсан спортын арга хэмжээний 10443 (60.4%) нь Сургууль, ААНБ-ын арга хэмжээ байсан бол 5009 (26.8%) нь сум, дүүрэг, баг хорооны, 1390 (7.1%) нь аймаг, нийслэлийн чанартай байна. Биеийн тамир спортын 2017 онд зохион байгуулагдсан арга хэмжээний тоогоор хамгийн их нь Төв (2305), Дорнод (2297) аймаг болон Улаанбаатар хот (2232) бол хамгийн бага нь

Говьсүмбэр (75), Дархан-Уул (165), Дорноговь (213), Сүхбаатар (234) аймгууд байна.

Зураг 4. Олон улсын чанартай арга хэмжээнд оролцсон хүний тоо, бүсээр



Эх сурвалж: Биеийн тамир, спортын улсын үзлэг тооллого 2017

Монгол Улсад 2017 онд биеийн тамир, спортын нийт 32 олон улсын чанартай арга хэмжээ зохион байгуулагдсаны Улаанбаатар хотод 12, Дорнод аймагт 10, Дорноговь аймагт 4, Төв аймагт 3, Баян-Өлгий аймагт 2 арга хэмжээ зохиогджээ. Нийт зохиогдсон арга хэмжээнд 10437 хүн хамрагдсаны 4780 (45.8%) нь эмэгтэйчүүд байна. Оролцогчдын 4374 (41.9%) нь Улаанбаатар, 3301 (31.6%) нь Төв аймаг, 1770 (16.9%) нь Дорнод аймагт зохиогдсон арга хэмжээнд хамрагдсан байна.

Биеийн тамир, спортын салбарын ажиллагчид: Биеийн тамир спортын салбарт 2018 оны байдлаар 2.7 мянган ажиллагчид ажиллаж байна. Үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл, спортын клубд 2.0 мянган буюу 74.0 хувь нь ажиллаж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ	АЖИЛЛАГЧДЫН ТОО
Спортын тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагаа	111
Спортын клубын үйл ажиллагаа	1,981
Спортын бусад үйл ажиллагаа	586
Нийт	2,678

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хороо, Ажиллах хүчний судалгаа

Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь: Биеийн тамир спортын салбарын ДНБ 2016 оны байдлаар 9.9 тэрбум төгрөг болж, нийт ДНБ-ий 0.04 хувийг бүрдүүлжээ.

Биеийн тамир, спортын салбарын нэмэгдэл өртгийн нийт эдийн засагт эзлэх хувь:

	НИЙТ	ҮҮНЭЭС:	
		СПОРТЫН САЛБАР	ЭЗЛЭХ ХУВЬ
ДНБ, худалдан авагчийн үнээр, сая төг	23,942,866.4	9,891.6	0.04

Олон улсын туршлага, жишээ

Гадаадын улс орнууд зохион байгуулсан спорт боон урлагын аливаа арга хэмжээ нь эдийн засгийн хувьд ямархуу хувь нэмэр оруулсан талаар судалж нийтэд мэдээлж танилцуулж байдаг. Эдгээрээс 2 жишээг толилуулж байна.

ОХУ-д болсон хөлбөмбөгийн ДАШТ

ОХУ-д болсон ДАШТ-ний нийт хувь нэмэр нь ДНБ-ний нэг хувьтай тэнцэхээр 850 гаруй тэрбум рубль болжээ. Оросын арга хэмжээг зохион байгуулах хорооны үнэлгээгээр тэр нь бараг бүх зарлагыг нөхөж чаджээ.

“McKinsey” консалтингийн компанийн гаргасан үнэлгээгээр, 2023 он хүртэл Орос нэмэлтээр 10 тэрбум рублийн ашиг олох ажээ. Ростуризм гэх жуулчны агентлагийн мэдээгээр 2,9 сая гадаадын жуулчид энэ үеэр Орост ирсэн байна. 2013-2023 онд ДНБ-ний хэмжээ 2-2,5 хувиар өснө гэж тооцсон. Тэмцээний өмнөх бэлтгэл ажил нь Оросын ДНБ-д 14 тэрбум долларын хувь нэмэр оруулж, 220 мянган ажлын байр бий болгосон байна. Хэрвээ хөлбөмбөгийн ДАШТ болоогүй бол Оросын эдийн засагт ийм хэмжээний өсөлт гарахгүй байх байсан. Их Британийн Euromonitor судалгааны компанийн хийсэн дүгнэлтээр бол, ДАШТ-ий дараа Оросыг зорих жуулчдын тоо улам нэмэгдэх аж. 2018 онд гадаадын жуулчдын тоо 1,4 хувиар өсөх бол 2022 он хүртэлх хугацаанд жуулчдын тоо жил бүр 4 хувиар өссөөр 37,5 саяд хүрэх төлөв харагдаж байна.

Токио 2020 олимпийн наадам

Япон улс нь 10.5 их наяд ам.доллар буюу ДНБ-ийх нь 230 хувьтай тэнцэхээр өртэй, эдийн засгийн хувьд хүндрэлтэй байгаа өнөө үед 2020 оны олимп зохион байгуулах асуудал хурцаар хөндөгдөж байгаа билээ. Наадамд зориулж 80 мянган хүний суудал бүхий шинэ цэнгэлдэх болон Олимпийн хотхоныг барих бөгөөд тус бүрт нэг тэрбум ам.доллар зарцуулна гэсэн тооцоо бий. Энэ мэт хэтэвчээсээ

хэтэрсэн зардал гаргаж байгаа нь эдийн засгийг сэргээх бодлого гэж шижээчид үзэж байна.

Олимп зохион байгуулах эрхийн төлөө өрсөлдөх болсноос хойш Японы эдийн засаг өсөх болсон. 2019 оны хоёрдугаар улиралд л 3.8 хувиар тэлээд буй эдийн засгийн эл өсөлт өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 1.2 хувиар ахисан үзүүлэлт гаржээ. Түүнчлэн Японы эдийн засгийн шинжээчид Олимпын наадмын ачаар тус улсын ДНБ 0.3 хувиар өсөх таамаг гаргаад байна. Тус наадмыг зохион байгуулахаар Японы Засгийн газар 7.5 тэрбум ам.доллар төсөвлөж, 30 тэрбум ам.долларын ашиг олно хэмээн үзсэн төдийгүй 150 мянган ажлын байр шинээр бий болгоно гэсэн хүлээлттэй байгаа аж.

Японы улсын аялал жуулчлалын салбар сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж, арлын орныг зорих гадаадын зорчигчдын тоо тасралтгүй нэмэгдсээр.

2018 онд л гэхэд тус улсад 31.19 сая зочин хүрэлцэн иржээ. Энэ нь 10 жилийн өмнөхтэй харьцуулахад дөрөв дахин өссөн үзүүлэлт бөгөөд “Маш их хэмжээгээр нэмэгдсэн” хэмээн JNTO буюу Японы үндэсний аялал жуулчлалын байгууллагын мэдээнд дурьдсан байна.

Үүний үр дүнд жуулчдын хэрэглээ Японы эдийн засагт тухайн ондоо 4.5 их наяд иен буюу өнөөгийн ханшаар 48 орчим тэрбум ам.долларын орлого оруулж, хамгийн их хэмжээгээр нэмэгджээ. Харин Абэ Шинзогийн Засгийн газар энэ дүнг 2020 он гэхэд 8.0 их наяд иен буюу 85 орчим тэрбум ам.долларт хүргэж, бараг хоёр дахин нэмэгдэнэ гэж танилцуулсан.


4. БИЕЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Спортын хувьд Турко, Келси (1992) нар эдийн засгийн нөлөөллийг "Спортын арга хэмжээ, байгуулахтай холбоотой зардлаас үүдсэн эдийн засгийн цэвэр өөрчлөлт" гэж тодорхойлдог. Хэдийгээр энэхүү онолыг спортын чиглэлээр тусгайлан зааж өгсөн боловч урлаг, соёлын салбарт болж буй үйл явдлуудад адилхан бөгөөд бизнесийн арга хэмжээ, чуулганд ч мөн хамааралтай байх боломжтой юм.

Эдийн засгийн цэвэр өөрчлөлтийг хэмжихдээ мөнгөн урсгал орж ирэхээс гадна гарах зардлыг мөн авч үздэг. Эдийн засгийн нөлөөллийн гол элементүүд бол зочин ба зохион байгуулагчийн зарцуулалт юм. Жуулчны зардал буюу зочдын зардал гэдэг нь үзэгчид, оролцогчид гэх мэт хүмүүстэй холбоотой зочдоос газарзүйн тодорхой бүсэд зарцуулах нэмэлт зардлыг хэлнэ.

Биеийн тамир, спортын салбарын эдийн засагт үзүүлэх нөлөөллийг дараах байдалд авч үзлээ.

Зураг 2. Биеийн тамир, спортын салбарын эдийн засгийн нөлөөллийн бүдүүвч



Эдийн засгийн нөлөөллийг 2 түвшинд авч үзлэг. Үүнд:

1. Макро эдийн засагт үзүүлж буй нөлөөлөл буй ДНБ-ий өсөлтөд үзүүлж буй нөлөө
2. Тухайн уралдаан тэмцээний үр ашгийн үзүүлэлт буюу 1 удаагийн арга хэмжээний нөлөөлөл

Нийгэмд хамгийн их ашиг тустай спортын төрөл нь дараах шинжийг агуулсан байдаг.* Үүнд:

- Олон үндэстэн хичээллэж, сонирхдог байх,
- Оролцогч талууддаа зохих хэмжээний дэмжлэг үзүүлдэг байх,
- Ямар нэгэн улс, гуравдагч хүчин зүйлсээс хамааралгүй шударга өрсөлдөх боломж
- Олон нийтийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтын загварууд нь нийтийг хамарсан спортод хөрөнгө оруулалт хийвэл их хэмжээний ашиг, нийгмийн үнэ цэнэ бий болгодог гэж үздэг.

Зураг 3. Эдийн засагт үзүүлж буй нөлөөллийн загвар



Шууд бус нөлөөлөл жишээ: 2018 онд World Health Organization гаргасан судалгаанд спортоор хичээллэхгүй бол нийт иргэдийн нас богиносж, залуу болон өсвөр насны хүмүүсийн дунд архидалт, хар тамхи хэрэглэх нь ихсэх, ажилгүйдэл бий болж эдийн засгийн өсөлтөд хор нөлөөтэй гэж үр дүн гарсан

Шууд нөлөөллийн үзүүлэлт

- ДНБ-ий өсөлтийн хувийн жин
- Олон жилийн дунджийн зөрүү
- Салбаруудын ДНБ-ийн өсөлт /Спорт, аялал жуулчлал, ХОРЕКА салбар, тээвэр, худалдаа г.м

Шууд бус нөлөөллийн үзүүлэлт

- Хүн амын орлого

- Ажилгүйдлийн түвшин
- Өвчлөлт
- Нийгмийн сэтгэл зүй

4.1 Макро эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцох аргачлал

Эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг тооцохдоо ЭЗҮАСА – аас дараах салбарт хамаарах ААНБ – ийн үзүүлэлт бүрд харгалзах мэдээллийг сонгоно. Өөрөөр хэлбэл дараах хүснэгт дэх салбаруудыг хамааруулж үзнэ. Салбаруудын дэлгэрэнгүй тайлбарыг 1 – р хавсралтаас харна уу.

Биеийн тамир спортын салбарын хүрээг тогтоохдоо зарим улс орон дан ганц спортын клубийн үйл ажиллагаагаар хэмжихгүйгээр холбогдох хувцас үйлдвэрлэл, худалдаа, боловсрол, мөрийтэй тоглоом (хуулийн хүрээнд явагддаг) зэргийг хамруулж, эдийн засагт оруулж буй хувь нэмрээр тооцдог байна.

Хүснэгт 1. Аргачлалд ашиглах салбаруудын код, нэр

№	Код	Салбарын нэр	
1	3230	Спортын бараа үйлдвэрлэл	C1
2	4764	Тоглоомын төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа	C2
3	7721	Амралт, зугаалгын болон спортын барааны түрээс, лизингийн үйл ажиллагаа	C3
4	8541	Спорт, чөлөөт цагт зориулсан боловсрол олгох	C4
5	9311	Спортын тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагаа	C5
6	9312	Спортын клубийн үйл ажиллагаа	C6
7	9319	Спортын бусад үйл ажиллагаа	C7
8	6020	Телевизийн өргөн нэвтрүүлэг бэлтгэх болон дамжуулах үйл ажиллагаа	C8
9	9200	Мөрийтэй тоглоом зохион байгуулах, явуулах үйл ажиллагаа	C9

3.1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь: Хүснэгт 1 дэх дэд салбаруудын оны үнээрх ДНБ-ий хэмжээг улсын нийт ДНБ-ий хэмжээнд харьцуулж, хувиар илэрхийлж тооцно.

$$\text{ДНБ хувь} = \frac{C1 + \dots + C9}{\text{ДНБ нийт}} * 100 \quad (1)$$

Энд:

ДНБ хувь – Биеийн тамир, спортын салбарын нийт ДНБ-д эзлэх хувь

C1 – Биеийн тамир, спортын салбарын дэд салбарууд

ДНБ нийт – Нийт дотоодын нийт бүтээгдэхүүн

Мэдээллийн урсгал: Тооцоонд ашиглагдах мэдээллийг жилд 1 удаа буюу жил бүрийн 5 дугаар сарын 25-ны дотор ҮСХ-оос авна.

3.2. Салбарын аж ахуйн нэгж, байгууллагын тоо: Биеийн тамир спортын салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын тоог тодорхойлохдоо ЭЗҮАСА – ийн хамаарах код бүхий ҮСХ – ний Статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй ААНБ-ыг сонгож, хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, дундаж ажиллагчдын тоо, жилийн дундаж борлуулалтын орлого зэргийг тооцно.

$$\text{ААНБ хувь} = \frac{C1 + \dots + C9}{\text{ААНБ нийт}} * 100 \quad (2)$$

Энд:

ААНБ хувь – Биеийн тамир, спортын салбарын ААНБ-ын нийт ААНБ-ын дүнд эзлэх хувь

C1 – Биеийн тамир, спортын салбарын дэд салбарууд

ААНБ нийт – Нийт дотоодын нийт бүтээгдэхүүн

Мэдээллийн урсгал: Тооцоонд ашиглагдах мэдээллийг буюу хүснэгт 1-д хамаарах дэд салбарт хамаарах тухай жилд үйл ажиллагаа явуулсан ААНБ-ын тоо, тэдгээрийн хариуцлагын хэлбэр, өмчийн хэлбэр, дундаж ажиллагчдын тоо, жилийн дундаж борлуулалтын орлого зэрэг мэдээллийг жилд 1 удаа буюу дараа оны 5 дугаар сарын 25-ны дотор ҮСХ-оос авна.

3.3. Ажиллагчдын тоо: Хөдөлмөрийн насны хүн амд үндэслэн тооцно. Хүснэгт 1 дэх дэд салбаруудад ажиллаж байгаа хөдөлмөрийн насны хүн амыг улсын нийт хөдөлмөрийн насны хүн амд харьцуулж, хувиар илэрхийлж тооцно.

$$\text{АЖИЛЛАГЧИД хувь} = \frac{C1 + \dots + C9}{\text{ХҮН АМ нийт}} * 100 \quad (3)$$

Энд:

АЖИЛЛАГЧИД хувь – Биеийн тамир, спортын салбарын нийт хөдөлмөрийн насны хүн амд эзлэх хувь

C1 – Биеийн тамир, спортын салбарын дэд салбарууд

ХҮН АМ нийт – Хөдөлмөрийн насны нийт хүн ам

Мэдээллийн урсгал: Тооцоонд ашиглагдах мэдээллийг жилд 1 удаа буюу жил бүрийн 5 дугаар сарын 25-ны дотор ҮСХ-оос авна.

3.4. Хувцасны нөөц: Тухайн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлд тухайн бүтээгдэхүүний импортын хэмжээг нэмж, экспортын хэмжээг хасаж тооцно. Энэхүү үзүүлэлт үнийн дүнгээр илэрхийлэгдэнэ.

Энэ тохиолдолд БТКУС-ын “барааны код – 6112” – д хамаарах экспорт, импортын хэмжээг авч үзнэ.

$$\text{ХН} = \text{ДҮ} + \text{ИМ} - \text{ЭК} \quad (4)$$

Энд:

ХН – Хувцасны нөөц

ДҮ – Хувцасны дотоодын үйлдвэрлэл

ИМ – Хувцасны импорт

ЭК – Хувцасны экспорт


Мэдээллийн урсгал: Тооцоонд ашиглагдах мэдээллээс хувцасны дотоодын үйлдвэрлэлийн хэмжээг жилд 1 удаа буюу дараа жилийн 5 дугаар сарын 25-ны дотор ҮСХ-оос авна. Харин экспорт, импортын мэдээллийг ГЕГ-аас дараа жилийн 5-р сарын 1-ний дотор авна.

4.2 Уралдаан тэмцээний эдийн засгийн нөлөөллийг тооцох аргачлал

Олон улсад зохион байгуулагддаг ихэнх арга хэмжээний хувьд үзэгчид буюу тухайн арга хэмжээнд оролцож буй хүмүүсийн тоо, тэдгээрийн зарцуулалт дээр үндэслэн эдийн засгийн нөлөөллийн тооцоолдог.

Ингэхдээ дараах бүдүүвчийн дагуу эдийн засгийн нөлөөллийг тооцдог.

Зураг 4. Арга хэмжээний эдийн засгийн нөлөөллийн бүдүүвч



Эдийн засгийн нөлөөллийг тооцохдоо хот, аймаг сум гэх мэт бүс нутгаар нь хязгаарлан тодорхойлох нь чухал. Энэ нь аймаг, сум, хөдөө орон нутагт эдийн засгийн шууд нөлөөллийг үзүүлэх магадлал өндөр байдагтай холбоотой.

Эдийн засгийн нөлөөллийн хэмжээг олон боломжтой орлогын хэмжээ болон гарах зардлын зөрүүгээр тодорхойлсон. Нэг удаагийн тэмцээн уралдааны эдийн засгийн ашиг/алдагдлын өнөөгийн үнэ цэнийг дараах загвараар гаргасан.

$$\sum_{t=0}^T \frac{1}{(1+r)^t} * (1+\beta)^t * W - \sum_{t=0}^T \frac{1}{(1+r)^t} * (1+\gamma)^t * W * \delta$$

Энд:

r – Хорогдуулалтын хүү

β – Орлогын өсөлт

W – Орлогын дундаж түвшин

γ – Зардлын өсөлт

T – Үргэлжилэх дундаж хугацаа

δ – Уралдаан тэмцээний зардлын түвшин

Дээрх загвараар ерөнхий орлого зарлагын харьцааг тооцоолон эдийн засгийн үр өгөөжийг тооцох боломжтой ба харин нэг удаагийн тээмцээн уралдаанаас олж болох орлого болон гаргах зардлын хэмжээг доорх алхмаар тооцоолно.

Үзэгчдийн зарцуулах зардлыг хэмжих

Арга хэмжээг зохион байгуулагчид эдийн засгийн нөлөөллийг тодорхойлохын тулд үзэгчдийн зарцуулах зардлыг тогтоох явдал юм. Үүнд дараах хэсэг багтана.

- 2.1-ээс 2.5-р алхмуудад зохих үзэгчдийн тоог тооцоолох.
Энэ нь тус үйл ажиллагаанд оролцож буй үзэгчдийн нийт тоог хэлэх бөгөөд үүнийг оршин суугчид болон энгийн зочдоор ялгаж тооцолдог.
- 2.6 - 2.8-р алхмуудад үзэгчийн зардлын загварыг хэрхэн яаж тооцоолохыг авч үзнэ. Үүнд үзэгчдийн зарцуулалтын загвартай холбоотой судалгааны өгөгдлийг авч, зохих үзэгчдийн тоонд оруулах (2.1-ээс 2.5-д заасны дагуу) орно.

Эрх бүхий үзэгчдийн тоог тооцоолох гол алхмуудыг доор харуулав.

Алхам 2.1 Арга хэмжээнд оролцох нийт үзэгчдийг тодорхойлох

Алхам 2.2 Дахин давтан үзэгчийн тооцоог хасах

Алхам 2.3 Орон нутгийн оршин суугчид

Алхам 2.4 Энгийн зочид

Алхам 2.5 Үзэгчдийн төрлийг авч үзэх

Алхам 2.1- Арга хэмжээнд оролцох нийт үзэгчдийг тодорхойлох

Үзэгчдийн зарцуулалтын тооцооны нарийвчлал нь ирцээсээ хамаарна. Нарийн бүртгэлийг ихэвчлэн, албаны хүмүүс, хэвлэл мэдээллийн ажилтнууд гэх мэт итгэмжлэгдсэн бүлгүүдтэй холбоотой зохион байгуулагчдаас авах боломжтой.

Томоохон арга хэмжээнүүдэд явуулсан судалгаагаар эдийн засагт үзүүлэх нөлөөллийн гол хүчин зүйл нь тухайн арга хэмжээнд оролцсон үзэгчдийн тоо юм.

Алхам 2.2 - Дахин давтан үзэгчийн тооцоог хасах

Үзэгчдийн ирцийг тооцохдоо нийт үзэгчид ба зочид хоорондын ялгааг ойлгох ёстой. Хэрэв арга хэмжээ нэгээс олон байршилд зохион байгуулагдсан тохиолдолд үзэгчид давтан үзэх магадлалтай тул үзэгчдийн нийт жингийн тоог бууруулж тооцоолох нь зүйтэй юм.

Энэ нь тасалбартай байсан ч гэсэн зарагдсан тасалбарын тоо болон ирсэн хүмүүсийн бодит тоо хоёрын хооронд ялгаа гарч болзошгүй юм. Гэсэн хэдий ч, шаардлагатай мэдээллийг тасалбар борлуулалтын мэдээллийн сангаас авах нь арга хэмжээнд оролцсон хүмүүсийн тоог мэдэх боломжтой.

Жишээлбэл: Дэлхийн Somersault аварга шалгаруулах тэмцээнд үзэгчид дунджаар хоёр өдөр оролцсон гэсэн тооцоо байдаг. Тиймээс 25,000 үзэгчдийн тоог тооцохдоо нэг өдөрт ирсэн 12,500 хүнд үндэслэн хийсэн.

Алхам 2.3 - Орон нутгийн оршин суугчид

Арга хэмжээ зохион байгуулагдаж буй орон нутгийн хувьд оршин суугчдын зарцуулалт нь тухайн бүс нутгийн мөнгөний эргэлт болох юм. Иймд тодорхой нөлөөллийн бүсэд тогтмол оршин суудаг хүмүүсийн зардлыг "жингүй" гэж тооцож, эдийн засгийн шууд нөлөөллийн тооцоонд оруулдаггүй.

Дэлхийн Somersault аварга шалгаруулах тэмцээний хувьд үзэгчдийн 50% нь Лондонгийн оршин суугчид байсан гэсэн таамаглал байдаг. Тиймээс 6,250 хүнийг эдийн засгийн нөлөөллийн тооцоонд хамруулахаас чөлөөлөлсөн байна.

Алхам 2.4 - Энгийн зочид

- Арга хэмжээг үзэх нь тухайн бүсэд байх гол шалтгаан нь биш иргэд. Жишээлбэл, Шотландаас ирсэн хэн нэгэн нь Лондонд найз нөхөд, хамаатан садандаа очсон. Энэ нь дэлхийн Somersault аварга шалгаруулах тэмцээнийг үзэх гол шалтгаан биш байсан бөгөөд үүнтэй холбоотой аливаа зардлууд бусад зүйлсээс үл хамааран гарсан
- Жуулчид өөрсдийн айлчлах хугацааг тухайн үйл явдалтай зэрэгцүүлэн өөрчилсөн. Жишээлбэл, Лондонд айлчлахаар төлөвлөж байсан иргэн Дэлхийн Somersault тэмцээний эргэн тойронд мөн аялахаар төлөвлөсөн

байна; гэхдээ аялалтай холбогдох зардал өөр цаг үед байсан ч хамаагүй хийгдэх байсан.

Орон нутгийн оршин суугчдын нэгэн адил энгийн зочингийн зардлыг эдийн засгийн нөлөөллийн зорилгоор “Жингүй” гэж үзэх нь зүйтэй.

Алхам 2.5 - Үзэгчдийн төрлийг авч үзэх

Аливаа арга хэмжээнд эдийн засгийн оролцооны шинж чанараараа бүлэглэж болох янз бүрийн үзэгчид оролцдог.

- Арилжааны зочид - Зочид буудал, зочны байшин эсвэл бусад худалдааны байрыг ашигладаг.
- Арилжааны бус оршин суугчид - Төлбөргүй байранд, жишээлбэл найз нөхөд, хамаатан садныдаа ирдэг зочид.
- Өдрийн зочин - Арилжааны болон арилжааны бус оршин суугч.

Энэ ангиллын үндэслэл нь эдгээр дэд бүлгүүдийн зарцуулалтын хэв маяг ижил биш юм. Товчхондоо, Арилжааны зочид нь арилжааны бус оршин суугчид болон өдрийн зочидоос илүү их мөнгө зарцуулах магадлалтай байдаг. Үүнтэй адилаар арилжааны бус хүмүүс оршин суух хугацаа нь илүү урт байдаг тул өдрийн зочидтой харьцуулахад эдийн засагт илүү нөлөөлдөг. Тиймээс эдгээр дэд бүлгүүдийг тусад тооцоолох хэрэгтэй.

Дэлхийн Somersault аварга шалгаруулах тэмцээний үеэр Лондонгийн бус үзэгчдийн 15% нь худалдааны зочид, 10% нь худалдааны бус, үлдсэн нь (75%) нь өдрийн зочид байсан гэж тооцоолжээ.

2.1-2.5-р алхамуудыг тооцох - Жишээ: Дэлхийн Somersault аварга шалгаруулах тэмцээн

	Жишээ	Тооцоолол
Алхам 2.1 - Арга хэмжээнд нийт үзэгчдийг тодорхойлох		
Нийт үзэгчдийн тоо	25,000	A
Алхам 2.2 - Дахин давтагчийг арилгана		
Жишээ нь. Үзсэн арга хэмжээний өдрийн дундаж тоо	2	B
Өөр өөр үзэгчдийн тоо	12,500	C=A/B
Алхам 2.3 - Орон нутгийн оршин суугчид		

Хост эдийн засаг дахь оршин суугч үзэгчдийн %	50%	D
Орон нутгийн бус үзэгчид	6,250	$E=(1-D)/C$
Алхам 2.4 - Энгийн зочид		
Орон нутгийн бус үзэгчдээс энгийн зочин %	20%	F
Арга хэмжээний тодорхой зочдын тоо	5,000	$G=(1-F)/E$
Алхам 2.5 - Үзэгчдийн төрлийг авч үзэх		
Арилжааны оршин суугчид	750 (15%)	H
Арилжааны бус оршин суугчид	500 (10%)	I
Өдрийн зочин	3,750 (75%)	J

Үзэгчдийн зарцуулалтыг хэмжих (2.6-2.8-р алхамууд)

Эрх бүхий үзэгчдийн тоог өмнөх алхамуудын (2.1-ээс 2.5-ын алхамууд) дагуу тооцоолсоны дараа үзэгчидтэй холбоотой нийт зарцуулалтын тооцоог гаргахын тулд тэдгээр үзэгчийн зарцуулалтын загварыг нарийвчлан, авч үзэх шаардлагатай. (2.6-28-р алхамууд).

Алхам 2.6 Үзэгчдийг орон сууцанд зарцуулахыг тооцоолох

Алхам 2.7 Бусад үзэгчдийн зарцуулалтыг тооцоолох

Алхам 2.8 Шууд алдагдлыг хасах

Алхам 2.6 Үзэгчдийн орон сууцны зарцуулалтыг тооцоолох

Орон сууц нь эдийн засгийн нөлөөллийн судалгаанд зарлагын хамгийн чухал зүйл нь болж байдаг. Үүнтэй холбогдуулан зочдын байр сууцанд зарцуулах тооцоо найдвартай байх ёстой. Орон сууцны салбарт үзүүлэх нөлөөллийг дараах байдлаар тооцоолоход харьцангуй энгийн юм.

Худалдаа эрхлэгчдийн тоо

x Тухайн бүсэд амьдарсан дундаж хоногийн тоо

= Арилжааны хоногийн тоо

x Нэг хоногийн дундаж зардал

= Үзэгчид орон байранд зарцуулах зардал

Алхам 2.7 - Бусад үзэгчдийн зарцуулалтыг тооцоолох

Зочдын зарцуулалтыг бүртгэх, тооцоолох зорилгоор зарлагын зургаан төрлийг авч үзнэ. Үүнд:

- Хоол, ундаа
- Үзвэр үйлчилгээ
- Орон нутгийн аялал (жишээ нь Автобус, Такси гэх мэт)
- Бараа бүтээгдэхүүн
- Дэлгүүр / бэлэг дурсгалын зүйлс
- Бусад (жишээлбэл, бензин, машины зогсоол)

Дээрх зардлын төрөлд тасалбарын зардлыг оруулаагүй. Учир нь тасалбар нь арга хэмжээ зохион байгуулагчдын орлогын нэг хэсэг болдог бол дээр дурдсан зүйлс нь ихэвчлэн дотоодын худалдаачдын орлогын хэлбэр болдог. Арга хэмжээг зохион байгуулагчдын тасалбарын борлуулсаны орлого, хөтөлбөрөөс олж байгаа орлого нь ихэвчлэн тухайн арга хэмжээ зохион байгуулах зардалд шууд зарцуулагддаг.

Алхам 2.8 - Шууд алдагдлыг хасах

Энэ нь орон нутгийн бус худалдаа эрхлэгчидтэй холбоотой аливаа зардал нь тухайн бүсийн эдийн засагт шууд нөлөөлдөггүй.

Хүснэгт 2. Эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээ

	Эдийн засагт үзүүлэх нөлөө		
	Эерэг	Дундаж	Сөрөг
Орон нутгийн иргэдийн зарцуулалт			
Орон нутгийн бус иргэдийн зарцуулалт			
Орон нутгийн оршин суугчид орон нутгийн худалдаачдаас худалдан авалт хийх			
Зочид орон нутгийн бус худалдаачдаас худалдан авалт хийх			
Орон нутгийн худалдагчдын зарцуулалт			
Зохион байгуулагч нарын худалдан авалтын зарцуулалт			

Орон нутгийн оршин суугчид орон нутгийн бус борлуулагчдаас худалдан авалт хийх			
--	--	--	--

Дараах жишээ нь зөвхөн үзэгчдэд хамаарна. Орон сууцны бус зүйлсийн хувьд зочдын зардлыг дээр дурдсан 2-р алхамд санал болгосон зардлын 6 ангиллаар хувааж үзэж болно.

Хүснэгт 3. Эдийн засгийн нөлөөллийн тооцооллын хүснэгт

	Жишээ	Тооцоолол
Алхам 2.6 - Үзэгчдын орон сууцны зарцуулалтыг тооцох		
Худалдааны Stayers-ийн тоо	750	H
Хоногийн тоо	2	K
Нийт хоногийн зарцуулалт	1,500	$L=H*K$
Нэг хоногийн дундаж зардал	50	M
Орон сууцны салбарын орлого	75,000	$N=L*M$
Алхам 2.7 - Бусад үйл явдалтай холбоотой зочдын зарцуулалтыг тооцоолох		
Арга хэмжээний зочдын тоо	5,000	G
Зочилсон өдрийн дундаж тоо	2	B
Өдрийн тоо	10,000	$O=G*B$
Орон сууцны бус зүйлд зарцуулах өдрийн дундаж зардал	30	P
Орон сууцны бус зарцуулалт	300,000	$Q=O*P$
Алхам 2.8 – Шууд алдагдлыг хасах		
Зочин нь орон нутгийн бус худалдаачидаас худалдан авалт хийх	75,000	R
Үзэгчдийн зарцуулалт	300,000	$S=N+Q-R$

Дээрх алхмын дагуу нөлөөллийг тооцон үр ашгийн үзүүлэлтийг гаргана.

5. МЭДЭЭЛЛИЙН ЭХ ҮҮСВЭР

Үндэсний статистикийн хороо: Дотоодын нийт бүтээгдэхүүн
Ажиллах хүчний судалгаа
Статистикийн бизнес регистрийн сан

Гаалийн ерөнхий газар: Экспорт, импортын мэдээлэл

Түүвэр судалгаа

Уралдаан тэмцээний үед авах асуулга, судалгааны хуудас

6. САНАЛ ЗӨВЛӨМЖ

Биеийн тамир, спортын салбарын эдийн засгийн нөлөөллийг тооцсоноор хүн амын эрүүл мэнд, зан төлөвт үзүүлж буй нөлөөллөөс гадна эдийн засагт үзүүлж буй үр өгөөжийг тооцох боломж бүрдэх юм. Энэхүү аргачлал нь манай улсад анхлан хэрэгжүүлж буй учир бодит жишээнд тулгуурлах, тооцооллын нарийвчлалыг турших ажлууд хангалттай хэмжээнд хийгдээгүй болно. Гэсэн хэдий ч цаашид сайжруулан боловсронгуй болгох чиглэлд анхаарлаа хандуулан ажиллана гэдэгт итгэж байна. Энэхүү аргачлалыг боловсронгуй болгох хүрээнд дараах зүйлд цаашид анхаарч ажиллах нь зүйтэй байна. Үүнд:

Биеийн тамир, спортын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа салбаруудын дэлгэрэнгүй бүртгэлтэй болж, салбарын эдийн засагт эзлэх байр суурийг илүү тодорхой болгох. Тухайлбал:

- Спортын бараа үйлдвэрлэл
- Тоглоомын төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа (спорт тоглоом)
- Амралт, зугаалгын болон спортын барааны түрээс, лизингийн үйл ажиллагаа
- Спорт, чөлөөт цагт зориулсан боловсрол олгох
- Телевизийн өргөн нэвтрүүлэг бэлтгэх болон дамжуулах үйл ажиллагаа (спорт суваг)
- Мөрийтэй тоглоом зохион байгуулах, явуулах үйл ажиллагаа (спортын төрөл болгох хууль эрх зүйн орчин бүрдүүлэх)

Үүний нэг удаагийн улсын хэмжээний судалгаа явуулах, холбогдох big data (уламжлалт бус мэдээлэл) ашиглах

Биеийн тамир, спортын арга хэмжээний эдийн засгийн нөлөөллийг тооцоход шаардлагатай мэдээллийг бий болгох. Шууд бус аргаар эдийн засгийн нөлөөллийг тооцоход шаардлагатай үзүүлэлт, норматив тоо мэдээлэл бий болгох түүвэр судалгааг хэрэгжүүлэх шаардлагатай.

Биеийн тамир, спортын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийн хүрээг тодорхойлсноор эдийн засагт төдийгүй нийгэм, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг тодорхойлох шаардлага мөн бий болно.

Код	Салбарын нэр, түүний тайлбар
-----	------------------------------

3230 Спортын бараа үйлдвэрлэл

Энэ ангид спортын зориулалттай бараа болон тамирчдын хэрэгсэл (хувцас, гутлаас бусад) үйлдвэрлэл орно:

- спортын төрөл бүрийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, гудамжны болон заалны спорт тоглоомын тоног төхөөрөмж үйлдвэрлэл: хатуу, зөөлөн хийлдэг бөмбөг; төрөл бүрийн цохиур; цана, татлага, тулгуур; усан завь, усны цана; спорт загасчлалын хэрэгсэл болон тор; ан ав, ууланд авирах хэрэгсэл; спортын зориулалттай арьсан бээлий, малгай; тэшүүр, дугуйт тэшүүр гэх мэт; нум сум; гимнастик, бие бялдаржуулах болон хөнгөн атлетикийн тоног төхөөрөмж

Энэ ангид дараах үйлдвэрлэл орохгүй:

- *завины дарвуул үйлдвэрлэл (1392-т),*
- *спортын хувцас, хэрэглэл үйлдвэрлэл (1410-т),*
- *морины тоноглол үйлдвэрлэл (1512-т),*
- *ташуур, морин спортын бусад хэрэгслийн үйлдвэрлэл (1512-т),*
- *спортын гутал үйлдвэрлэл (1520-т),*
- *спортын зэр зэвсэг, сум үйлдвэрлэл (2520-т),*
- *хүндийн өргөлтийн төмөр туухай үйлдвэрлэл (2599-т),*
- *боулингийн зам, бусад автомат хэрэгсэл үйлдвэрлэл (2829-т),*
- *спорт дугуй бусад хэрэгсэл, чарганы үйлдвэрлэл (29 ба 30-р дэд салбарт),*
- *завь үйлдвэрлэл (3012-т),*
- *биллиардын ширээ үйлдвэрлэл (3240-т),*



Код	Салбарын нэр, түүний тайлбар
-----	------------------------------

- чих болон хамар хамгаалах хэрэгсэл (жишээлбэл, усанд сэлэлтийн болон чимээнээс хамгаалагч) үйлдвэрлэл (3290-т орно).

4764 Тоглоомын төрөлжсөн дэлгүүрийн жижиглэн худалдаа

Энэ ангид бүх төрлийн материалаар хийсэн тоглоомын жижиглэн худалдаа орно.

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй:

- удирдлагатай видео тоглоомын жижиглэн худалдаа (4741-д),
- видео тоглоомын программын жижиглэн худалдаа (4741-д орно).

7721 Амралт, зугаалгын болон спортын барааны түрээс, лизингийн үйл ажиллагаа

Амралтын усан онгоц, завь, далбаат завь, дугуй, эргийн сандал, нарны халхавч, шүхэр, цана болон спортын бусад төхөөрөмж зэрэг амралт зугаалга, спортын барааны түрээс энэ ангид орно.

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй:

- видео хуурцаг, дискийн түрээс (7722-т),
- хувийн болон өрхийн хэрэглээний бусад барааны түрээс (7729-т),
- чөлөөт цаг, амралтын зугаалгын газрын тоног төхөөрөмжийн түрээс (9329-т орно).

8541 Спорт, чөлөөт цагт зориулсан боловсрол олгох

Код	Салбарын нэр, түүний тайлбар
-----	------------------------------

Энэ ангид зуслан болон сургуулиар дамжуулан хувь хүн болон бүлэг хүмүүст зориулан биеийн тамир, спортын зааварчилгаа өгөх сургалт орно. Мөн оройн болон өдрийн биеийн тамир спортын зааварчилгаа өгөх сургалт орно. Харин мэргэжил олгох их, дээд сургууль, коллежийн боловсролын хөтөлбөр орохгүй. Зааварчилгааг хувь хүнд зориулсан, бүлгээр, сургалтын байгууллага, бусад хэлбэрээр олгож болно. Энэ хэсэгт ангилагдсан сургалт нь ихэвчлэн албан ёсоор зохион байгуулагдсан байна.

Энэ ангид дараах сургалт орно:

- биеийн тамир, спортын сургалт /сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг, крикет гэх мэт/
- хөгжөөн дэмжих багийн сургалт
- гимнастикийн сургалт
- морь унах сургалт
- усанд сэлэх сургалт
- мэргэжлийн спортын зааварчилгаа, багш, дасгалжуулагч
- цэргийн урлагийн сургалт
- бие хамгаалах урлагийн сургалт
- хөзөр тоглож сурах зааварчилгаа
- йог болон дасгал хийх сургалт

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй:

- соёлын боловсрол олгох (8542-т орно).

Энэ ангид дараах үйл ажиллагаа орно:

- гадаа болон байгууламж дотор зохиогддог спортын арга хэмжээний үйл ажиллагаа (нээлттэй, үзэгчийн суудалтай, суудалгүй, хаалттай): хөлбөмбөг, хоккей, крикэт, бейсбол, задгай талбай, цэнгэлдэх хүрээлэн; авто машин, морь болон бусад амьтдын уралдааны зам; усан сан ба стадион; өвлийн уралдааны талбай ба хүрээлэн; мөсөн хоккейн талбай; боксын дэвжээ; гольф; боулингийн зам; тураах төв
- өөрийн спортын байгууламжтай байгууллагаас мэргэжлийн тамирчид, эсвэл сонирхогчдод зориулж ил задгай буюу танхимд спортын арга хэмжээг зохион байгуулах, явуулах

Мөн энэ ангид эдгээр арга хэмжээг зохион байгуулах ажилтнаар хангах, удирдах үйл ажиллагаа багтана.

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй:

- амралт, цэнгээний болон спортын тоног төхөөрөмжийг түрээслэх (7721-т),
- цанаар гулгах, амралтын газар болон далай, гол мөрний эргийн үйл ажиллагаа (9329-т орно).

9312 Спортын клубийн үйл ажиллагаа

Энэ ангид мэргэжлийн, хагас мэргэжлийн эсвэл сонирхогчийн клуб, спорт клубийн үйл ажиллагаа болон тэдгээр клубийн гишүүдийг спортын арга хэмжээнд оролцох боломжийг олгохтой холбогдох үйл ажиллагаа багтана.



Код	Салбарын нэр, түүний тайлбар
-----	------------------------------

Энэ ангид спортын клубийн үйл ажиллагаа; хөл бөмбөгийн; боулингийн; усанд сэлэлтийн; гольфийн; боксын; бялдаржуулах; өвлийн спортын; шатрын; уралдаан болон талбайн; буудлагын зэрэгт клуб орно.

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй:

- *хувийн багш, дасгалжуулагч нарын спортын сургалт (8541-т),*
- *өөрийн спортын байгууламжтай спортын клубүүдээс мэргэжлийн тамирчин эсвэл сонирхогчдод зориулж гадаа эсвэл танхимд спортын арга хэмжээг зохион байгуулах (9311-т орно).*

9319 Спортын бусад үйл ажиллагаа

Энэ ангид дараах үйл ажиллагаа орно:

- спортын арга хэмжээний продюсер, зохион байгуулагч өөрийн байгууламжтай, эсвэл үгүй байж болно.
- бие даан хичээллэдэг тамирчин болон атлетик, тэмцээний шүүгч, шүүгч, туслагчийн үйл ажиллагаа
- спортын холбоо, зохицуулагч байгууллагын үйл ажиллагаа
- спортын арга хэмжээг явуулахад дэмжих үйл ажиллагаа
- уралдааны морь, нохой зэргийг байрлуулахад зориулсан мал, амьтны зүчээ, үүр, хашаа хорооны үйл ажиллагаа
- спортын загас барилт, ан агнуурын захиалгын үйл ажиллагаа
- уулын спортын тамирчдын газарчны үйл ажиллагаа
- спортын, эсвэл сонирхогчийн ан агнуур, загас барилтыг зохион байгуулахад туслах үйл ажиллагаа

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй:

- уралдааны морийг өсгөж, үржүүлэх үйл ажиллагаа (0142-т),
- спортын тоног төхөөрөмжийг түрээслэх үйл ажиллагаа (7721-т),
- спортын сургууль, сургуулийн спорт тоглоомын үйл ажиллагаа
- спортын зааварлагч, багш, дасгалжуулагчдын үйл ажиллагаа (8541-т),
- спортын клуб нь өөрийн тоног төхөөрөмж, талбайг ашиглан зохион байгуулсан мэргэжлийн болон сонирхогчийн спорт арга хэмжээний үйл ажиллагаа (9311/9312-т),
- цэцэрлэгт хүрээлэн болон наран шарлагын газрын үйл ажиллагаа (9329-т орно).

6020 Телевизийн өргөн нэвтрүүлэг бэлтгэх болон дамжуулах үйл ажиллагаа

Энэ ангид агаарын долгионоор телевизийн өргөн нэвтрүүлгийг дамжуулах студи болон хөтөлбөрийг дамжуулах телевизийн сувгийг дуу өгөгдлийн хамт цацах үйл ажиллагаа орно.

Энэ ангид үйлдвэрлэгч нэгж өөрөө эсвэл, кабелийн телевизийн компани, хиймэл дагуулын телевизийн үйлчилгээ үзүүлэгч гэх мэт гурав дахь дистрибьютерээр дамжуулан дуу, дүрс, тоон өргөдлийн хөтөлбөрийг хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагаа орно. Хөтөлбөрийн цагийн хуваарийг гаргахдаа өөрсдөө гаргадаг эсвэл бусдын мэдэлд байж болно. Хөтөлбөрүүд нь ихэвчлэн төрөлжсөн байна (тухайлбал, мэдээллийн, спортын, боловсролын, залуучуудад чиглэсэн гэх мэт).



Код	Салбарын нэр, түүний тайлбар
-----	------------------------------

Энэ ангид спортын, киноны, мэдээллийн, боловсролын сувгийн хөтөлбөр бэлтгэх үйл ажиллагаа орно.

Энэ ангид дараах үйл ажиллагаа орно:

- Ай Пи телевиз (IPTV)
- Хөдөлгөөнт телевиз (Mobile TV)
- Агаарын болон олон сувгийн телевиз

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй:

- *телевизийн хөтөлбөрийн элементүүдийг бүтээх (кино, баримтат бичлэг, сурталчилгаа гэх мэт) (5911-т),*
- *кабель эсвэл сансрын сувгийг үзэгчдэд хүргэх үйл ажиллагаа (61-р дэд салбарт орно).*

9200 Мөрийтэй тоглоом зохион байгуулах, явуулах үйл ажиллагаа

Энэ ангид дараах мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа багтана:

- бооцоо авах үйл ажиллагаа, бооцоотой холбогдох бусад үйл ажиллагаа, морин тойруулгын гаднах мөрний тоолуур, казино, түүний дотор хөдөлгөөнт казиногийн үйл ажиллагаа, сугалааны билетийн борлуулалт, мөнгө хийхээр ажилладаг, мөнгөн хонжвортой автомат тоглоомын үйл ажиллагаа /ашиглалт/, боломжит мөрийтэй тоглоомтой веб сайтыг удирдах
- мөнгө хийхээр ажилладаг, мөнгөн хонжвортой, автомат тоглоомын машины үйл ажиллагаа



Код	Салбарын нэр, түүний тайлбар
-----	------------------------------

- виртуал мөрийтэй тоглоомын цахим хуудасны үйл ажиллагаа
- картын тоглоом болон бусад мөрийтэй тоглоомын үйл ажиллагаа
- бооцоо, мөрийтэй тавьдаг уралдаант тоглоом
- казиногийн (завин дээрх казино-г оруулан) үйл ажиллагаа

Энэ ангид дараах үйл ажиллагаа орохгүй.

- мөнгө хийж ажиллуулдаг тоглоомын үйл ажиллагаа (9329-т орно).

